

Нэг. ТАНЫ АНХААРАЛД

Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэн (УЦУОСМХ)-ийн Орчил урсгал, урт хугацааны прогнозын судалгааны хэлтэс (ОУУХПСХ)-ээс 2020 оны 9, 10, 11 дүгээр саруудын урьдчилсан төлөвийг тооцоолон танд хүргэж байна.

Урьдчилсан төлөвийг <http://www.tsag-agaar.mn/> цахим хуудсанд сар бүрийн 25 гэхэд сарын урьдчилсан мэдээ болон гурван сарын урьдчилсан төлөвийг шинэчлэн гаргадаг тул хэрэглэгч та бүхэн тухай бүрд нь шинэчилсэн мэдээг ашиглаж байна уу.

Дэлхийн Цаг уурын байгууллагаас тогтоосноор олон жилийн дундаж (ОЖД) утга гэдэгт 1981-2010 оны хоорондох тухайн цаг уурын хэмжигдэхүүний дундаж утгыг авч үздэг.

Намрын улирлын төлөвийн талаар лавлах шаардлагатай бол УЦУОСМХ-ийн 11-326606 утсаар холбогдох болон тус хүрээлэнгийн ОУУХПСХ-ээс тодруулах боломжтой.

Хоёр. ТОЙМ

2.1 9-11 дүгээр сарын уур амьсгал

Уур амьсгалын дунджаар агаарын сарын дундаж температур есдүгээр сард Их нууруудын хотгор, Алтайн өвөр говь, говийн нутгийн өмнөд хэсгээр +14..+19°C, Алтай, Хангай, Хөвсгөлийн уулсаар 2°C хүйтнээс 6°C дулаан, бусад нутгаар +6..+14°C байдаг бол 10 дугаар сард Алтайн өвөр говь, говийн нутгийн өмнөд хэсгээр +2..+10°C, Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар -2..-10°C, бусад нутгаар 2°C хүйтнээс 3°C дулаан байдаг. Харин 11 сард тогтвортой хүйтэн болж Алтайн өвөр говь болон говийн бүс нутгаар -1..-8°C, Алтай, Хангай, Хөвсгөлийн уулархаг нутгаар -12..-20°C, бусад нутгаар -6..-12°C болж хүйтэрдэг байна.

Хур тунадасны хувьд 9 дүгээр сараас борооны хэмжээ багасаж, орох тохиолдол нь цөөрдөг ба төв ба зүүн зүгийн нутгийн хойд хэсгээр 32-44 мм, баруун ба говийн нутгаар 4-15 мм, бусад нутгаар 17-30 мм бороо ордог ба зарим сэрүүн жилд сарын сүүлчээр уулархаг нутгаар нойтон цас ордог. Харин 10 дугаар сард баруун зүгийн нутгийн хойд хэсгээр, 11 дүгээр сард төв болон зүүн зүгийн нутгийн зарим газраар 10 – 18 мм, бусад нутгаар 0 – 6 мм хур тунадас ордог байна.

Намрын эхний цочир хүйтрэлт наймдугаар сард уулархаг нутаг болон газар тариалангийн бүс нутгаар голчлон ажиглагддаг. Есдүгээр сард цочир хүйтрэлт ажиглагдах тохиолдол нэмэгддэг онцлогтой.


Намрын улиралд (9 – 11 сард) салхины хурд ихэсдэг бөгөөд Алтайн салбар уулс, Арц богдын өвөр хоолой болон говийн бүс нутгаар 15 м/с – ээс дээш хурдтай салхитай өдрийн тоо ОЖД – аар 3 – 7 өдөр байдаг бол бусад нутгаар 0 – 2 өдөр ажиглагддаг байна.

Гурав. 9-11 ДҮГЭЭР САРЫН УРЬДЧИЛСАН ТӨЛӨВ

3.1 2020 оны IX-XI сарын цаг агаарын мэдээ

Есдүгээр сард. Сарын дундаж агаарын температур ОЖД – аар Баян-Өлгий, Хөвсгөлийн ихэнх нутаг, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төв аймгийн зүүн хойд хэсгээр 4°C хүйтнээс 6°C дулаан, Өмнөговь, Дорноговийн нутаг, Говь-Алтай, Баянхонгорын өмнөд хэсгээр 14 – 20°C, бусад нутгаар 6 – 14°C дулаан байдаг.


9 дүгээр сарын агаарын дундаж температур Сэлэнгийн зүүн, Төвийн зүүн хойд, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр ОЖД – аас хүйтэн, бусад нутгаар ОЖД – ийн орчим байх төлөвтэй байна (Зураг 1).



Зураг 1. 9 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв(С⁰)

Сарын нийлбэр хур тунадас ОЖД – аар Сэлэнгийн нутаг, Хөвсгөл, Булган, Төв, Хэнтий, Дорнодын хойд хэсгээр 30-40 мм, Баян-Өлгий, Ховд, Говь-Алтай, Баянхонгор, Өмнөговь, Дундговь, Дорноговийн ихэнх нутаг, Увсын баруун, Завхан, Сүхбаатарын баруун өмнөд, Өвөрхангайн өмнөд хэсгээр 4 – 15 мм, бусад нутгаар 15 – 30 мм хур тунадас ордог.


9 дүгээр сарын нийлбэр хур тунадас Баянхонгорын өмнөд, Өмнөговийн өмнөд хагас, Дорноговийн баруун өмнөд хэсгээр ОЖД – аас ахиу, бусад нутгаар ОЖД – ийн орчим хур тунадас орох төлөвтэй байна (Зураг 2).



Зураг 2. 9 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв(мм)

Араедугаар сард. Сарын дундаж агаарын температур ОЖД – аар Баян-Өлгий, Хөвсгөлийн ихэнх нутаг, Завханы зүүн, Баянхонгорын хойд, Архангайн баруун, Төв аймгийн зүүн хойд хэсгээр 2 – 10°C хүйтэн, Өмнөговь, Дорноговийн нутаг, Говь-Алтайн, Баянхонгор, Өвөрхангай, Дундговийн өмнөд хэсгээр 4 – 8°C, бусад нутгаар 2°C хүйтнээс 3°C дулаан байдаг.


10 дугаар сарын агаарын дундаж температур Булган, Сэлэнгэ, Төв, Дорнодын ихэнх нутаг, Хөвсгөл, Архангайн зүүн, Хэнтийн хойд хэсгээр ОЖД – аас дулаан, бусад нутгаар ОЖД – ийн орчим байх төлөвтэй байна (Зураг 3).



Зураг 3. 10 дугаар сарын агаарын температурын урьдчилсан төлөв(С°)

Сарын нийлбэр хур тунадас ОЖД – аар баруун болон говийн аймгуудын ихэнх нутгаар 3 – 6 мм, бусад нутгаар 7 – 15 мм хур тунадас ордог.


10 дугаар сарын нийлбэр хур тунадас нийт нутгаар ОЖД – ийн орчим хур тунадас орох төлөвтэй байна (Зураг 4).



Зураг 4. 10 дугаар сарын хур тунадасны урьдчилсан төлөв(мм)

Арваннэгдүгээр сард. Сарын дундаж агаарын температур ОЖД – аар Баян – Өлгий, Хөвсгөл, Завханы ихэнх нутаг, Увс, Сэлэнгэ, Төв аймгийн зүүн, Арангай, Хэнтийн баруун, Баянхонгорын хойд хэсгээр 12 – 20°C хүйтэн, Өмнөговийн ихэнх нутаг, Ховд, Говь – Алтай, Баянхонгор, Өвөрхангай, Дорноговийн өмнөд хэсгээр 4°C хүйтнээс 2°C дулаан, бусад нутгаар 4 - 12°C хүйтэн байдаг.


11 дүгээр сарын агаарын дундаж температур нийт нутгаар ОЖД – аас дулаан байх төлөвтэй байна (Зураг 5).



Зураг 5. 11 дүгээр сарын агаарын температурын урьдчилсан төлөв(С°)

Сарын нийлбэр хур тунадас ОЖД – аар Сэлэнгийн ихэнх нутаг, Увс, Завхан, Хөвсгөл, Төв, Хэнтийн хойд, Ховд, Архангайн өмнөд, Булганы зүүн, Дорнодын баруун хэсгээр 5 – 10 мм, бусад нутгаар 0 – 4 мм хур тунадас ордог.

11 дүгээр сарын нийлбэр хур тунадас нийт нутгаар ОЖД – ийн орчим хур тунадас орох төлөвтэй байна (Зураг 6).



Зураг 6. 11 дүгээр сарын хур тунадасны урьдчилсан төлөв(мм)

3.2 2020 оны намрын улирлын онцлог

Урьдчилсан төлөвөөс харахад 9 дүгээр сард ихэнх нутгаар ОЖД – ийн орчим байх бол, 10 дугаар сард нутгийн баруун болон өмнөд хэсгээр, 11 дүгээр сард ихэнх нутгаар ОЖД – аас дулаан дулаан байх төлөвтэй байна. Хур тунадасны хувьд ихэнх нутгаар ОЖД – ийн орчим байх боловч 9 дүгээр сард нутгийн өмнөд хэсгээр ОЖД – аас ахиу хур тунадас орох төлөвтэй байна.

Түүнчлэн намрын эхний цочир хүйтрэлт наймдугаар сард уулархаг нутаг болон газар тариалангийн бүс нутгаар голчлон ажиглагддаг бол есдүгээр сараас эхлэн говийн бүс нутгаар ажиглагддаг.

Мөн 9 болон 10 дугаар сард нойтон цас орж, тариа хүнсний ногоо цасанд дарагдах, 9 – 11 сард салхины хурд ихсэж, цасан болон шороон шуурганы давтагдал ихсэх зэрэг байгаль цаг агаарын тааламжгүй нөхцөл ажиглагдаж болзошгүйг анхааруулж байна.